

## МОНГОЛ ДАХЬ ЯПОНЫ ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ТҮҮНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

*Д.Начин\**

Хөгжиж байгаа орнуудаас Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа, Зүүн Өмнөд Ази, Зүүн Хойт Азид гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын урсгал хүчтэй байгаа бөгөөд зөвхөн Хятад улс 2002 онд 53 тэрбум ам.долларын буюу хамгийн их гадаадын хөрөнгө оруулалт татаж чадсан байдаг. Үүний дотор Монголд орж байгаа ГШХО-ын хэмжээ сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдсээр байгаа юм.

Монголд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр Зүүн Ази, Хойт Америкийн хөрөнгө оруулагчид тэргүүлж байгаа бөгөөд энэ өгүүлэлд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны болон Японы хөрөнгө оруулалтын тухай өгүүлэх болно.

Монгол Улсын Засгийн газраас гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг дэмжих эрх зүйн акт нь “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хууль бөгөөд энэ хуулинд хөрөнгө оруулалтын илүү тааламжтай орчинг бий болгоход чиглэгдсэн тодорхой нэмэлт өөрчлөлтүүдийг 1993, 1998, 2002 онуудад оруулсан юм. Гадаадын хөрөнгө оруулагчид нь Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай өнөөгийн мөрдөж байгаа хуулиар хар тамхи, буу, тэсрэх бодис үйлдвэрлэх, садар самууныг сурталчлах зэргээс бусад чиглэлээр хөрөнгө оруулалт хийх боломжоор хангагдсан бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглоно. Гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад Монголын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгох гэх зэрэг урамшуулал үзүүлдэг. Монгол Улсын Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдад орлогын албан татварын тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг.<sup>1</sup>

Мөн түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчид нь Монгол Улсын Засгийн газартай Тогтвортой байдлын гэрээ байгуулах (2 сая ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулалт оруулсан), Монгол Улсад аж ахуйн нэгж бүртгүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, гадаадын хуулийн этгээдийн салбар байгуулах эрхтэй.

ГШХО нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, бусад хууль, тогтоомж болон Монгол Улсын

\*Д.Начин - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ахлах мэргэжилтэн

нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан байдаг юм.

Монгол Улсын Засгийн газар нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” хэлэлцээрт 31 улстай, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т 37 улстай тус тус гарын үсэг зурсан ба “Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” 1965 оны Вашингтоны конвенцид 1996 онд, “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” 1985 оны Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон. Монгол Улсын Засгийн газраас байгуулсан худалдааны гэрээ хэлэлцээрүүд, ялангуяа АНУ, Европын Холбоотой байгуулсан худалдааны нэн тааламжтай гэрээнүүд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал нөлөө үзүүлж байгаа болно. Монгол Улс нь Дэлхийн Банкны Хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн/MIGA/ гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчид MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй гэдгийг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газар нь Япон улсын Засгийн газартай 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т гарын үсэг зурсан нь Японы хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэх эрх зүйн үндэс, хүчин зүйл болсноос гадна Японы Itochu, Sumitomo, Nissho Iwai, Osaka Cashmere, Mitsubishi зэрэг компаниудын төлөөлөгчийн газар Монголд байгуулагдан ажиллаж байгаа нь чухал нөлөөтэй билээ.

Монгол Улсын төр засгаас уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг гадаадын хөрөнгө оруулалтыг татах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарууд гэж тодорхойлдог бөгөөд дээрх салбаруудад хөрөнгө оруулалт хийхэд тодорхой дэмжлэг, урамшууллыг үзүүлдэг. Тухайлбал, Засгийн газраас 2001 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын жагсаалтын дагуу үр тариа, эрчимжсэн мал аж ахуй, нүүрс, газрын тос, ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэл, үслэг эдлэл, арьс шир боловсруулалт, мод, модон эдлэл, төмөрлөг, химийн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эдийн боловсруулалт, дэд бүтцийн зарим салбар, аялал жуулчлал зэрэгт хамаарагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд гадаадаас орж ирж буй технологийн

зориулалттай тоног төхөөрөмж нь НӨТ, гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалтыг татах гадаад болон дотоодын таатай эрх зүйн орчин Монголд бүрэлдэн тогтож, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдсээр байгаа юм.

2003 оны эцсийн байдлаар Монгол Улсад орсон гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн дүнгээр нэг тэрбум гаруй ам.долларт хүрсэн бөгөөд Японы хөрөнгө оруулагчид хамтарсан буюу дагнасан 167 аж ахуйн нэгж байгуулж, нийт 60.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүний ихэнх нь 58.3 хувь буюу 28.1 сая ам.доллар хөнгөн үйлдвэрийн салбарт ноогдож байгаа бөгөөд хөнгөн үйлдвэрийн (сүлжмэл, ноолуур боловсруулах) салбарт хамгийн их /36.5 хувь/ хөрөнгө оруулжээ. Харилцаа, холбооны салбарт 8.1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн нь салбарын хувьд мөн хамгийн их /48.4 хувь/ хөрөнгө оруулалт болж байна. 2003 онд Япон улс нь 6.8 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулбал бараг 2.5 дахин өссөн үзүүлэлт юм.

Японы бизнес эрхлэгчид 1990 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд хөрөнгө оруулалтын дийлэнх нь сүлжмэлийн үйлдвэрлэл, харилцаа холбооны салбарт орсон байдаг.

Эдгээрээс харилцаа холбооны үүрэн телефоны үйлчилгээг анх Монголд нэвтрүүлсэн Мобиком корпораци нь эдүгээ Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Налайх, Алтанбулаг, Замын-Үүд, Зуунмод, Багануур, Зүүнхараа, Сайншанд, Арвайхээр, Хархорин, Чойр, Булган, Хөтөл, Багахангай, Архангай, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дорнод, Ховд, Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Сүхбаатар зэрэг хот аймгуудыг хамарсан үүрэн телефон холбооны сүлжээтэй ба нийт 200 мянга гаруй хэрэглэгчдэд 24 орон нутгийн үйлчилгээний салбар, Улаанбаатар хотод 10 гаруй үйлчилгээний төв, 40 гаруй гэрээт борлуулагчдаар дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

Буюнхолдинг, Санширо компани ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэсэн ноос, ноолууран бүтээгдэхүүн нь манай хэрэглэгчдийн танил болсон байна.

Монголд хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулах боломж, бизнесийн үйл ажиллагаа явуулах муугүй нөхцөл байгааг харуулсан, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Японы хөрөнгө оруулалттай Буянхолдинг, Мобиком, Суругамонгол, Санширо, Жэй Эм интернет моторс компаниуд нь 2000-2003 онуудад 100 мянган ам.доллараас дээш хөрөнгө оруулалтыг харилцаа холбоо, ноолуурын үйлдвэрлэлд нэмж оруулснаас гадна гольфын тоглоомын үйл ажиллагаанд дахин хөрөнгө оруулсан болно.

Монголд Японы хөрөнгө оруулалттай нэлээд хэдэн компани автомашины засвар үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа эрхлэдэг бөгөөд эдгээрээс Моннис, Нимонс зэргийг дурьдаж болно. Дайнем инвестмент компани ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр дахин хөрөнгө оруулсан байна.

Японы хөрөнгө оруулагчид нь соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарт анхаарч ирсэн бөгөөд Соёл Эрдэм дээд сургууль нь гадаадын хөрөнгө оруулалтаар бий болсон анхны гадаад хэлний сургуулийн нэг юм. Мөн түүнчлэн Шинжлэх ухаан, технологийн Монэнзим интернэйшнл Монгол-Японы хамтарсан компани нь *Мишээл* гоо сайхны бүтээгдэхүүнээ Японы зах зээлд гаргаж эхлэсэн гэдгийг энд бас дурьдая.

Японы хөрөнгө оруулалттай олон компаниуд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж Японы жуулчидыг Монголтой танилцуулж байгаа болно.

Сүүлийн үед мэдээлэл, компьютерийн чиглэлээр Грэф сити зэрэг Монгол-Японы хамтарсан компани байгуулагдан ажиллаж байгаа болон Монголын энэ чиглэлийн зарим компани ч гэсэн Японы программ хангамжийн зах зээлд орохоор бэлтгэлээ ханган ажиллаж байна.

Монгол Улсын хамгийн том хандивлагч орон нь Япон улс бөгөөд өнгөрсөн хугацаанд манай орны дэд бүтцийн, үүнээс цахилгаан станцыг түлшээр хангах нүүрсний уурхайн үйл ажиллагаанд зориулж уул уурхайн техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн билээ. Эдгээр тоног төхөөрөмжүүдийн (гол төлөв КОМАЦУ компанийн) хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хангах зорилгоор Японы хөрөнгө оруулалттай КОМИТ компани байгуулагдсан нь албан ёсны зээл тусламжийг дагаж гадаадын шууд хөрөнгө оруулалт орж байгаа нэгэн жишээ юм.

Аялал жуулчлал, худалдаа, уул уурхайн салбарыг Японы хөрөнгө оруулагчид сонирхож байгаа бөгөөд Монголын бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэвшилтэд технологи, хүрээлэн буй орчинд хал багатай технологи нэвтрүүлэхэд Японы хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах нь чухал байна.

Геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт ийнхүү ихээхэн хэмжээний хөрөнгө дахин оруулах болсон нь Монгол Улсын

Засгийн газраас энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн тодорхой алхмууд, тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг 2001 онд, «Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл» «Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл» зэргийг 2002 онд баталсантай холбоотой гэж үзэж байна. Энд алт, зэсний ихээхэн нөөцтэй Оюу Толгойн ордыг ашиглалтанд оруулснаар Монгол Улсын ДНБ 2-3 дахин өснө гэсэн тооцоо байдгийг дурьдая.

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас сүүлийн жилүүдэд гадаадын шилдэг хөрөнгө оруулагчдыг шалгаруулж байгаа ба 2002, 2003 оны жагсаалтанд Мобиком, Буянхолдинг, Суруга монгол компани шалгаран орсон байгаа. Мобиком компани энэ жагсаалтанд 2 жил дараалан оржээ.

Энэ дашрамд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас эрхлэн Япон-Монголын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, бизнес уулзалтыг хоёр талд зохион байгуулах ажлыг тогтмолжуулсан нь хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэн хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Энэ бүгдээс үзэхэд Японы хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, тэр нь бодитой зүйл болон Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрийн зохих хувь нэмрээ оруулж байна гэж хэлж болохоор байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсын харьцангуй давуу талыг:

- Улс төр, хууль эрх зүйн тогтвортой байдал, нээлттэй эдийн засаг,
- ОХУ, БНХАУ хэмээх хоёр том зах зээлд нэвтрэх өргөн боломж;
- Ашигт малтмал, түүхий эдийн арвин их нөөц,
- Харьцангуй залуу, боловсролтой хүн ам,
- Өргөн уудам нутаг дэвсгэр, цэвэр, ариун байгальтай хэмээн тодорхойлдог

Энд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нааштайгаар нөлөөлж байгаа нэгэн шинэ хүчин зүйл бол Европ, Америк төвтэй дэлхийн уламжлалт зах зээл Ази, тэр дундаа БНХАУ руу чиглэн шилжиж байгаа явдал юм. Үүнийг АНУ, Япон зэрэг орнууд манай өмнөд хөршийн бараа, бүтээгдэхүүнийг импортлон БНХАУ-даашиг олох боломжийг урьд нь олгодог байсан бол эдүгээ худалдааны урсгал эсрэг тийш эргэж БНХАУ-ын импорт өсөж байна. Тухайлбал, Япон улсын БНХАУ-тай хийсэн худалдаа

2003 онд 51.7 хувиар өссөн эерэг тэнцэлтэй гарсан байна. Түүнчлэн ДХБ-д гишүүнээр элсэж ороходоо БНХАУ нь аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний импортын тарифыг 24.6 хувиас дунджаар 9.4 хувь хүртэл бууруулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортын тарифыг 31.5 хувиас 17.4 хувь хүртэл бууруулах үүрэг амлалт авсан. Иймд энэхүү асар том зах зээлийг бараадан дөхөх үүднээс гадаадын хөрөнгө оруулагчдад эдийн засгийн либерал бодлого, тогтолцоотой Монголыг сонирхох нь ирээдүйдээ үр ашигтай байх үндэслэлтэй юм. Үүнийг харгалзан Монголын төр, засгаас хоёр хөрштэйгээ түншлэлийн харилцааг эрчимтэй өрнүүлж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа болно.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол хөшүүрэг нь тухайн орны санхүү, эдийн засгийн өсөлт, хөгжлийн эрч далайц байдаг бөгөөд 2003 онд Монгол Улсын ДНБ-ний өсөлт 5.5 хувьд хүрч, 1991 онд 350 орчим хувь байсан инфляцын түвшин 4.7 хувьтай тэнцэж байв. Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд өсөх хандлага ийнхүү тогтворжсон тул 2003 оны 11 дүгээр сард Токио хотноо зохиогдсон Монголд хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалтаас манай орныг шилжилтийн үеэс өсөлтийн үед шилжсэн гэж дүгнэсэн.

ДНБ-д хувийн секторын эзлэх хувь 2003 онд бараг 80 хувьд хүрсэн нь манай бизнес эрхлэгчид ДНБ-ий өсөлтийг хангаж байна гэж үзэж болохоор болжээ. Манай бизнес эрхлэгчид зах зээлийн эдийн засгийн нөхцөлд аж ахуйн үйл ажиллагаа явуулах 10 гаруйхан жилийн туршлага хуримтлуулсан байгаа боловч банкнаас их өндөр хүүтэй зээл авч, бизнесийн үйл ажиллагаа явуулаад түүнийхээ дүнд банкныг хөлжүүлээд, хүн ажиллуулж ажлын байр бий болгоод, татвараа төлөөд ба өөрсөддөө ашиг олж чадах тийм хэмжээнд авхаалж самбаа, зориг сүйхээ гарган ажиллаж байгааг энэ өсөлтийн нууц гэлтэй.

Гадаадын хөрөнгө оруулагчдын хэзээд болгоомжилдог байсан Монголын төсөвт санхүүгийн тооцоолоогүй дарамт гарч ирэн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх нэгэн “эрсдэл” Монгол Улс, ОХУ-ын хооронд он дамнан яригдсаар ирсэн “их өр”-ийн асуудлыг 2003 онд амжилттай эцэслэн шийдвэрлэв.

Монгол Улсын ДНБ-д тээвэр, агуулахын аж ахуй, холбооны (16.5), санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны (13.5), барилгын (12.6) зэрэг салбарын нийт бүтээгдэхүүний өсөлт өндөр хувьтай байгаа бөгөөд эдгээр салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсээр байгаа болно.

Манай орны хувьд ДНБ-ий өсөлтөөс гадна ГШХО орох чадавхийн индексийг тодорхойлсон үзүүлэлтүүдийг<sup>2</sup> сайжруулах, ядаж хүрсэн хэмжээнд<sup>3</sup> нь барьж байх шаардлагатай бөгөөд энэ үзүүлэлтүүдээс телефон утас, гар утасны тоо нэмэгдэж байгаа, эрсдэлийн зэрэг буурч (зээлжих зэрэглэл<sup>4</sup> өсч) байгаа зэрэг нааштай зүйл бий. Мөн түүнчлэн их дээд сургууль, коллежийн оюутны тоо, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээтэй холбогдсон үзүүлэлтүүд нь эерэгээр нөлөөлж болох талтай. Энд мэргэжилтэй ажилчид бэлтгэх техник мэргэжлийн сургууль, инженер, техникчдийг бэлтгэх асуудал чухал юм.

Дээр дурьдсан тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарт багтаж байгаа мэдээлэл, холбооны салбарын нийт бүтээгдэхүүний өсөлт 14.5 хувь буюу ДНБ-ийхээс бараг 3 дахин илүү хурдацтай байгаа бөгөөд жилийн нийт орлогын хэмжээ 2003 онд 92.4 тэрбум төгрөгт хүрч 1999 оныхтой харьцуулахад бараг 4 дахин өсчээ. Энэ өсөлтийг жил дараалан нэмэгдэж байгаа суурин телефон цэг, гар утас хэрэглэгчдээс гадна өнөөдрийн байдлаар 11.2 мянгал хүрээд байгаа интернет хэрэглэгчтэй холбон үзэхээс гадна салбарын орлогыг нь холбоо (телефон, гар утас) болон мэдээллийн технологид хэрхэн хуваарилагдаж байгааг харах нь чухал. Холбооны дэд салбарын хувьд хэрэглэгчдийн тоо, үйлчилгээний нэр төрөл, тариф нь хязгаартай учир орлогын өсөлт тодорхой хэмжээнээс хэтрэхгүй болно. Харин мэдээллийн технологийн дэд салбарын хувьд орлого нь огцом өсөх боломжтой.

Аялал жуулчлалыг эс тооцвол үйлчилгээний экспортын хувь хэмжээ бага буюу тооцоолоход бэрхшээлтэй байна. Сүүлийн үед ажил үйлчилгээний экспортод хэдэн зуун тэрбум ам.доллараар хэмжигдэх зах зээлтэй компьютерийн программ хангамж чухал байр эзлэх болсон бөгөөд гол захиалагч нь АНУ, Япон, ХБНГУ, Их Британи зэрэг хөгжингүй орнууд бөгөөд Энэтхэг, БНСУ-ын программ зохиогчид энэ зах зээлийн үндсэн гүйцэтгэгчид нь болдог байна.

Компьютерийн программ хангамжийн үйлдвэрлэл нь орчин нөхцөл нь бүрдсэн тохиолдолд ажиллагсадын тоо, газар зүйн байршил, эдийн засгийн хүчин чадлаас үл хамааран богино хугацаанд хөгжилд хүргэж чадах бизнес юм.

Цөөн хүн амтай, жижиг эдийн засагтай, газар зүйн өвөрмөц байршил, өргөн удам нутаг дэвсгэртэй учир тээврийн өндөр зардалтай манай орны хувьд компьютерийн программ хангамжийн экспортод онцгой анхаарал хандуулж судлах, улмаар шинээр бий болгож хэрэгжүүлэх нь улс орны хөгжлийн зангилаа асуудлын нэг юм.

Монгол Улсын Засгийн газраас сүүлийн жилүүдэд компьютерийн программ хангамжийн үйлдвэрлэлийн орчин бүрдүүлэх чиглэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн төвийг Улаанбаатар хоттой, Алтай-Улиастай, Ховд-Улаангом, Булган-Мөрөнг холбосон 1300 гаруй км урт бүхий өндөр хурдны шилэн кабелийн сүлжээг ашиглалтанд оруулснаар бүх аймгийн төвүүд тоон технологи бүхий үндсэн сүлжээнд холбогдож, улмаар нийслэл, томоохон хот, бүх аймгийн төв, суурин 30 гаруй газар үүрэн телефон холбооны үйлчилгээ нэвтэрч, хөдөлгөөнт холбоо хэрэглэгчдийн тоо сүүлийн 4 жилд 6 дахин өссөн байна. Саяхан Монголын төмөр зам нь БНХАУ болон ОХУ-ын төмөр замтай шилэн кабелиар холбогдсон нь төмөр замд орчин үеийн менежмент, холбооны технологи нэвтрүүлэх, мэдээлэл дамжуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, бизнесийн шинэ боломжийг нээн өгч байгаагаас гадна манай орны зүүн бүсийн шилэн кабелийн сүлжээнд дорвитой хувь нэмэр оруулж хөдөөгийн хэрэглэгчдэд мэдээлэл, холбооны үйлчилгээ үзүүлэх болно. Мэдээлэл, холбооны үйлчилгээг хөдөөгийн хэрэглэгчдэд хүргэхэд цахилгаан эрчим хүчний хангамж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах асуудлыг Монголын нөхцөл, тухайн хэрэглэгчийн онцлогт тохируулан шийдвэрлэх бодит шаардлага байгааг энд зориуд тэмдэглэх нь зүйтэй юм.

Сүүлийн үед манай компьютерийн программын зарим нэгэн компани бие даан эсвэл гадаадын компанийн салбарыг Монголд байгуулж бага хэмжээний захиалгат программ боловсруулах, тест хийх ажлыг хийж байна. Эдгээрээс гаалийн системд хэрэглэж байгаа GAMAS, зарим банкуудад хэрэглэж байгаа GLAXY, их дээд сургуульд хэрэглэж байгаа UNIMIS, олон улсын байгууллагын төслийн IMIS (Integration Management Information System), MONIS (Monitoring Information System) зэрэг систем нь гадаадын программ зохиогчдоос зохих ёсоор үнэлэгдсэн, тодорхой түвшинд хийгдсэн ажил болсон байна. Иймд энэ салбар нь гадаадын хөрөнгө оруулагчид, ялангуяа Японы хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах чиглэлийн нэг байж болох юм.

Даяарчлагдаж байгаа нөхцөлд барууны хөрөнгө оруулалтыг Монголын өрсөлдөх чадварыг бий болгох, улс орны хөгжлийн зангилаа асуудлын нэг хэмээн үзэж түүнийг татах асуудалд Монгол Улсын төр засаг онцгой анхаарч байдаг.

Японы хөрөнгө оруулагчдыг татах, ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний гүн боловсруулалт, эрчимжсэн хөдөө аж ахуй болон шинжлэх ухаанд суурилагдсан, ялангуяа биотехнологи, мэдээллийн технологийн чиглэлд татахыг зүйтэй гэж үзэж байна.



## ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. - Цахилгаан, дулааны станц, цахилгаан, дулаан дамжуулах шугам, сүлжээ, авто, төмөр зам, агаарын тээврийн болон инженерийн барилга байгууламж, харилцаа холбооны үндсэн сүлжээний салбарт 10 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

- Нефть, хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроникийн салбарт 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал тухайн аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас 3 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

2. Тухайн орны ДНБ-ний бодит өсөлт, нэг хүнд оногдох ДНБ, нийт экспорт, 1000 хүнд ногдох телефон утасны шугам, гар утасны тоо, арилжааны цахилгаан эрчим хүч хэрэглэх төвшин, судалгаа-шинжилгээнд гаргаж байгаа зардал, оюутны тоо, байгалийн баялагаа экспортлож байгаа болон электроникийн эд анги, автомашин импортолж байгаа байдал, ажил үйлчилгээний экспорт ба ГШХО-ын нийт хэмжээ зэрэгтэй уялдуулан улс орнуудын ГШХО орох чадавхийн индексийг тодорхойлсон байна.

3. НҮБХХБ-аас гаргасан судалгаагаар Монгол Улс 1999-2001 онд ГШХО-ын өндөр чадавхитай ангилалд багтах болсон байна.

4. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хувийн хөрөнгө оруулагчдаас зээлжих зэрэглэлээс нь хамаарч тухайн улс оронд үзүүлэх албан ёсны тусламжийн болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг. Стандарт энд Пүүрс компаниас хийсэн дэлхийн улс орнуудын зээлжих зэрэглэлийг нэр хүндтэйд тооцож, хүлээн зөвшөөрдөг байна.

Шилжилтийн гэгдэх эдийн засагтай орнуудын зээлжих зэрэглэл тогтооход дараах зүйлүүдэд голчлон анхаардаг байна. Үүнд:

· Улс төрийн ардчилсан систем бий болгож бүрдүүлэх чиглэлээр: Улс төрийн ардчилсан байгууллагуудын үйл ажиллагаа, түүний үр нөлөө, улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаа, ил тод байдал, эдийн засгийн шинэчлэл хийх улс төрийн мэдэгдэл ба түүнээ хэрэгжүүлэх чадвар.

· Санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн арга хэмжээний үр дүн. Үүнд инфляцийн төвшин, зээлийн хүүг бага байлгах, валютын тогтвортой хөрвөх ханшийг хангахад чиглэсэн санхүү/мөнгөний болон валют арилжааны бодлогын хэрэгжилт орно.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд суурилсан эдийн засагт хэрхэн шилжиж байгааг дараах зүйлүүдээр үнэлнэ.

- Улс орны эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг. Үүнд төрийн өмчийн хувьчлал, хувийн хэвшлийнхний эхлэл, үйлдвэрийн газруудын өөрчлөн зохион байгуулалт, компани, аж ахуйн нэгжүүдийн удирдлага- зохион байгуулалт, нийгмийн зүгээс татвар болон татвар төлөлтөд хандах ерөнхий хандлага зэрэгт өгөх үнэлгээ.

- Санхүүгийн сектор. Үүнд банкны систем, түүний хөгжил, санхүүгийн зуучлалд гарсан дэвшил, үнэт цаасны зах зээл, банк бус санхүүгийн байгууллагын хөгжилд өгөх үнэлгээ.

- Зах зээлийн байгууллагуудын хөгжил. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин, зах зээлийн механизмд зохицон ажиллах практик үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа байдалд үнэлэлт өгнө. Үүнд Оюуны өмчийг хамгаалах хууль тогтоомжууд, дампуурлын гэрээ хэлэлцээр, эд хөрөнгө барьцаалах тухай хууль зэрэг орж болно.

Гадаад худалдааны Дорнодоос Өрнөдөд чиглэсэн хандлага. Эдийн засгийн өсөлт, экспорт импортын харьцаа, тэдгээрийн цаг хугацааны хувьд тогтвортой байгаа эсэх, олон улсын эдийн засаг, худалдааны байгууллагад нэгдэн орсон, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь санхүүгийн эх үүсвэр болж байгаа байдал, удирдлага, технологи дамжуулал, компанийн удирдлага сайжирсан эсэхэд үнэлгээ өгнө.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2001, Төрийн Мэдээлэл 2001, # 34, Засгийн Газрын 2001 оны 140 дүгээр Тогтоол, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт батлах тухай, МУЗГ, Улаанбаатар

2. МУЗГ, 2002, Төрийн Мэдээлэл, 2002, №5, Гадаадын Хөрөнгө Оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль, МУЗГ, Улаанбаатар.

3. FDI in Mongolia 2003, Ulaanbaatar, Mongolia, BCI Co., Ltd.

4. Начин Д., 2004, Гадаадын шууд хөрөнгө оруулалт: Дэлхий дахины хандлага ба Монгол Улс, Олон Улс Судлал, 1, 2004, 51-60 хуудас

5. UNCTAD, 2003, World Investment Report 2003: FDI Policies for Development: National and International Perspectives, United Nations, New York and Geneva, 2003